

НИКАРАГУАГААС

мэндчилж байна!

Никарагуа бол Төв Америкт оршдог улс бөгөөд тэнд 7 сая орчим хүн амьдардаг!

САЙН МЭДЭЭГ ТҮГЭЭХ НЬ



1953 онд Никарагуад анхны номлогчид очжээ. Өнөөдөр 100 000 гаруй Сүмийн гишүүн тэнд байна! Тэнд бүр ариун сүм баригдаж байгаа.



НИКАРАГУА НУУРЫН АВАРГА ЗАГАС

Бух аварга загас давстай болон цэнгэг усанд амьдарч чаддаг. Энэ нь тэд далай, гол, нуурт амьдарч чадна гэсэн үг юм! Тэд Никарагуа нуурт амьдрахаар Атлантын далайгаас урт мөрнөөр дамжин сэлдэг.

¿Наки эсма?

гэдэг нь мискито хэлээр "Чи сайн уу?" гэсэн үг юм!



ПАЛО ДЭ МАЁ

Никарагуагийн хүмүүс борооны улирал ирэх үед Пало дэ Маёо хэмээх томоохон наадмыг зохион байгуулдаг. Тэд тойрон бүжиглэж, бүтэн сарын турш хөгжилдөхөөр мод эсвэл савааг өнгө өнгийн туузаар чимэглэдэг.



MONGOLIAN

Албан ёсны хэл нь испани хэл. Зарим хүн мискито, сумо, рама зэрэг нутгийн хэлээр мөн ярьдаг.

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ДЭЙВ КЛУГ



ҮЙЛ АЖИЛЛАГАА

Чувис

Чувис бол Никарагуагийн хүүхдүүдийн тоглодог нэг төрлийн наадгай юм. Энэ тоглоомыг тоглоход чамд ногоон шиш (саваа) бас нүх (аяга) хэрэг болно. Тоглогч бүрд таван ногоон шош өгнө. Эхний тоглогч ногоон шошоо нэг нэгээр нь нүх рүү шиднэ. Хэрэв тэд алдвал зогсох ба дараагийн тоглогчийн ээлж ирнэ. Таван ногоон шошоо бүгдийг нь нүхэнд оруулсан эхний тоглогч хожно!



ЖОР

Галлопинто

Никарагуад олон хүн будаа, хар шоштой энэ хоолыг өдөр бүр иддэг. Энэ хувилбарыг туршаад үзээрэй!

1. **2 цайны халбага тос, тал шар сонгиныг** халааж, 5 минут хольж хуурна.
2. **1 аяга тал цагаан будаа** хийн 2-оос 3 минут хутга.
3. **Давс, 3 аяга ус** нэм. **Таллаж хуваасан ногоон амтат чинжүүний** үрийг авч, дээр нь тавь.
4. Таглаад, ус нь ширгэх хүртэл 15 минут болгоно.
5. Болсон чинжүүг хаяж, **2 аяга болгосон улаан эсвэл хар шош** бас **тал цайны халбага саримсны нунтаг** хийж хутгаад, 10 минут болгоно.

Томчуудаас тусламж аваарай!